

**“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-Г ГАЛИГЛАХАД ХЭРЭГЛЭСЭН  
“馬” ҮСГИЙН ТУХАЙ**

**М. Жавхлан** \*

*Түлхүүр үг: Монгол хэл, монголын нууц товчоо, 馬 үсэг*

Монголд “Монголын нууц товчоо” хэмээх түүхийн сурвалж бичиг байна гэдгийг мэдэх, түүнийг эрж олох, олсон хойноо уншин судалж, агуулгыг нь ойлгох, хятад хүнд зориулан хятад үсгээр галиглах хүртэл олон арван жил өнгөрсөн болох нь мэдээжийн хэрэг билээ. Монгол зэрэг цагаан толгойн үсэгтэй, залгамал хэлний бичгийг үеийн бүтэц бүхий утга үсгээр галиглах гэдэг хэцүү хэрэг.

“Нэг хэлний авиаг ондоо хэлний авиагаар тэмдэглэхэд хүрвэл яасан ч бага сага зөрөө гарах нь аргагүй юм”<sup>1</sup>. Гэвч үүнийг тэр үеийн монгол ба хятад эрдэмтэд гайхалтай сайхан гүйцэтгэж чадсаныг батлах баримт олон байгаа аж.

“Монголын нууц товчоо” бол хятад үсгээр галигласан монгол хэлний чухал дурсгал билээ. Үүнд, “Монголын нууц товчоо”-г галиглахад хичнээн хятад үсэг хэрэглэсэн, галигласан үсгүүд нь хятад хэлэнд уулаасаа байсан эсэх, эсвэл “Монголын нууц товчоо”-г галиглахад зохиосон үсэг юм уу? гэх асуудлууд гарч байна. “Монголын нууц товчоо”-ны галиг үсгийг судалсан байдлаас үзвэл, Японы монголч эрдэмтэн Широ Хаттори “Монголын нууц товчоо”-ны өөр өөр бар хэвлэл, монгол хэлийг тэмдэглэсэн хятад үсгийн төрөл зүйл, түүнд хэрэглэсэн арга зарчим, тэдгээр үсгийн хятад хэлэн дэх дуудлага зэргийг судлаад номынхоо хавсралтад 563 хятад үсгийг жагсаан үзүүлсэн байна<sup>2</sup>.

Японы Монголч эрдэмтэн Ш. Озова “жиггээр “舌” үсэг гарч байна. Хятад хэлэнд байхгүй тохирох гийгүүлэгч “Г”-ыг илтгэж “舌兒” гэдэг үсэг нь зөвхөн гийгүүлэгч “Г” болсон байна”<sup>3</sup> гэжээ. Мөн “Морьтой нягт холбоотой “秣” гэх үсгийг хэрэглэж, цаашлаад “𠵿”-д нь бас “馬” гэдэг үсгийг дагалдуулж байв”<sup>4</sup> хэмээн дурдсан байна.

\* МУИС, Эх бичиг судлалын тэнхим, төслийн судалгааны ажилтан

<sup>1</sup>) Ш. Озова “ Монголын нууц товчооны ертөнц”, ӨМАХХ., 1998, 139-р тал.

<sup>2</sup>) Широ Хаттори “Монголын нууц товчоо”-н дахь монгол үгийг илтгэсэн хятад үсгийн судлал, Япон 1946, 139-р тал.

<sup>3</sup>) Ш. Озова “Монголын нууц товчооны ертөнц”, ӨМАХХ., 1998, 140-р тал.

<sup>4</sup>) Ш. Озова “Монголын нууц товчооны ертөнц”, ӨМАХХ., 1998, 142-р тал.

Өвөрмонголын эрдэмтэн, судлаач Хасбагана “Монголын нууц товчоо”-н дахь монгол хэлийг авиалан тэмдэглэсэн хятад үсгийг суурь үсэг, ижил авиаг тэмдэглэсэн үсэг, тэмдэглэсэн авиа гэж ангилан хүснэгтэлсэн байна<sup>5</sup>.

Өвөрмонголын эрдэмтэн, судлаач Шонхор “Монголын нууц товчоон”-д тохиолдож байгаа хятад үсгийг жагсаан бичихдээ жижиг “舌”, “中” хадсан үсгүүдийг тусдаа үсэг хэмээн үзэж 502 үсгийг жагсаан ангилжээ. Үүнд, гийгүүлэгч хятад үсгийн өмнө “舌” үсэг хадсан нь (г) гийгүүлэгч болохыг илэрхийлсэн байна<sup>6</sup> гэжээ.

Өвөрмонголын эрдэмтэн, судлаач Гарьд “Монголын нууц товчоон”-д монгол хэлийг голдуу үечлэн тэмдэглэх аргыг хэрэглэжээ. Үүнд, гийгүүлэгч үсэг бүхий байнга хэрэглэгдэх галиглалын үсгүүдээс хүснэгтлэн үзүүлсэн байна. Хятад галигт байнга тохиолдох үет үсгийн хүснэгт<sup>7</sup>: гийгүүлэгч (m), “馬” (ma), “蔑” (me), “米” (mi), “抹” (mo, mǒ), “木” (mu, mǔ) хэмээн “馬” үсгийг дурдсан байна.

“Монголын нууц товчоо”-г галиглахад энгийн байдалд хятад бичигтэй япон, солонгос, тайвань зэрэг улс орон болон хятадын эртний толь бичгүүдээс ч шүүн олдохгүй өдий төдий үсгийг хэрэглэсэн байдал ажиглагдаж байна.

## **“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-Г ГАЛИГЛАХАД “馬” ҮСГИЙГ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ**

Тус өгүүлэлд “Монголын нууц товчоо”-г галиглахад хэрэглэсэн “馬” үсэг хийгээд түүнд холбоотой үсгүүдийг бүртгэхийн хамт “Монголын нууц товчоо”-г галиглахад хэрхэн хэрэглэсэн байдлыг тайлбарлахыг зорьсон болно. “Монголын нууц товчоо”-г галиглахад ашигласан “馬” бүхий 12 үсэг 600 удаа давтагджээ.

### 1. “Монголын нууц товчоо”-ны “馬”

“Хятад хэлний их толь” (漢語大字典)-д “馬”-ыг “морь, хүлэг, агт, адуу” гэжээ. “馬” үсэг “Монголын нууц товчоо”-нд 399 удаа гардаг бөгөөд морьтой холбоотой утгаар биш, харин дуудлага тэмдэглэх үүргийг гүйцэтгэж байна.

### 2. “Монголын нууц товчоо”-ны “𠵹”

Aqta (12), aqta-yi (1), aqta-yin (3), aqta+tan (4), a[q]ta+tan (2), aqtan+tan-i (3), a[q]ta+tan-i (2), a[q]ta+tan-u (1), aqtači (1), \_aqtači (4), \_aqtači-da-an (1), \_ aqt ači-yi (1), aqtas (16), aqtas-ača (1), aqtas-iyān (5), a[q]tas-iyān (1), aqtas-iyar (1), aqtas-iyar-iyān (1), aqtas-tur-iyān (1), aqtas-tu (1) 62 удаа давтагддаг (-ta) гэсэн үе бий. Уул хятад үсэг “Хятад хэлний их толь” ба “Хятад монгол толь”-д байдаггүй.

Эрдэмтэн, судлаач Б. Сумъяабаатар “𠵹” (-ta) үсэг хэмээн үзжээ. Энэ үсгийг хятад хэлний их тольд “хi” хэмээх дуудлагатай, хар зүсэмтэй, нуруун дээрээ шар судалтай морь хэмээн тэмдэглэж буй. Тэгэхээр дуудлага, зурлагын хувьд тохирохгүй байна. Хятад хэлний их тольд 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹, 𠵹 зэрэг хятад үсгүүд буй боловч өмнө нь “馬”-тай үсэг байхгүй тул “馬” ба “𠵹”-г нийлүүлэн “𠵹” бүтээсэн байна. Хятад үсэгт “aγta”(𠵹) агттай холбоотой үсгийг галиглаж болохуйц –

<sup>5</sup>) Хасбагана “Дундад зууны монгол хэлний судлал”, ӨМСХХХ., 1996, 468-482-р тал.

<sup>6</sup>) Шонхор “Эртний монгол хэлний судлал”, ӨМСХХХ., 1996, 11-12-р тал.

<sup>7</sup>) Гарьд “Дундад эртний монгол хэлний судлалын үдиртгал”, ӨМАХХ., 2008, 98-р тал.

ta дуудлагатай үсэг олон буй боловч (ᠮᠠᠮᠠ) гэдэг үгэнд орж байгаа тул хятад хэлэн дэх үсгийн утгыг түлхүүр үсэг болгон бичих тогтолцоондоо (ᠮᠠᠮᠠ) морь гэсэн утгатай “馬” орсон “-ta”-гаар бичжээ. Иймээс “Монголын нууц товчоо”-г галиглахад зориулан шинэ үсэг зохиосон байна.

### 3. “Монголын нууц товчоо”-ны “騾”

“Монголын нууц товчоо”-нд бор (ᠪᠣᠷᠢ), (boru) гэсэн үгэнд нэг удаа гарч байгаа “孛騾” үсэг буй. “Хятад хэлний их толь”-д “騾”, (luo)-ийг луус, морь, илжиг хоёрын дундаас гарсан амьтан гэж нэрлэж буй. Энэ үсгийн зурлага зөрөөтэй боловч утга нь мөн нэг төрлийн морийг тэмдэглэсэн “騾” үсгийн өөр хэлбэр гэж ойлгоод энэхүү тэмдэгт үсгээр галигласан гэж болно.

### 4. “Монголын нууц товчоо”-ны “馬孛”

Эрдэмтэн, судлаач Б. Сумьяабаатар “馬”, (ma) ба “孛”, (bo, ei)-ийг хятад хэлэнд тус тусдаа бий гэж үзэв. “馬” ба “孛”-ийн нийлмэл хэлбэр “馬孛” нь “Монголын нууц товчоо”-г галиглахад зохиосон үсэг<sup>8</sup> хэмээн бичжээ. Харин “Хятад хэлний их толь”-д “馬孛”, (bo)-г хятадын эртний домогт гардаг нэг төрлийн морь, үхрийн сүүлтэй, цагаан биетэй, ганц эвэртэй хэмээн тэмдэглэж буй. Энэ үсэг “馬孛騾” гэх нэг үгэнд 2 удаа гардаг. Үлгэр, домогт гардаг морины нэр бор хэмээх үгийг галиглахад шууд ашигласан бөгөөд зохиосон үсэг биш юм.

### 5. “Монголын нууц товчоо”-ны “騾羅”

“馬孛騾羅” гэсэн үгэнд гарч байгаа “騾羅”-г эртний ба одоо үеийн хятад бичгийн толь бичгээс хайгаад олохгүй. Судлан ажиглаваас зөвхөн “Монголын нууц товчоо”-ны галигт бий. “舌” (she)-г дээд өнцөгт нь жижгээр бичиж “luo”-г “guo”-оор сэлгэн унших болгосон байна. Мөн “羅” (luo)-г морины утгатай галигт хэрэглэж байгаа учраас “馬”-г өмнө нь бичиж галиг үсэг болгосон байна.

### 6. “Монголын нууц товчоо”-ны “馬𠵼”

Күрибаяши “ge'ün” хэмээх үгийг “格𠵼”<sup>9</sup> хэмээн тэмдэглэжээ. 𠵼 нь “Монголын нууц товчоо”-ны “馬𠵼” үсэгтэй тохирохгүй байна. “馬𠵼” тэмдгийг бүртгэн үзэхэд (ᠮᠠᠮᠠ/ᠮᠠᠮᠠ) гэх ганц үгэнд нэг л удаа гардаг. Хятад хэлэнд ün-г галиглаж болмоор үсэг олон бий. “Монголын нууц товчоо”-г галигласан бичгийн эрдэмтэд (ᠮᠠᠮᠠ) гэсэн үгийг галиглах шаардлага тулгараад морьтой холбоотой (wen) дуудлагатайг хэрэглэсэн нь харагдаж байна. Тиймээс “馬”-г түлхүүр үсэг болгон “𠵼” үсэгтэй нийлүүлэн зохиоход хүрсэн байна. “馬𠵼” гэх нийлмэл үсэг хятад хэлний их тольд байхгүй.

<sup>8</sup>) Б.Сумьяабаатар, “Монголын нууц товчоо”-ны хэлбэр судлал”, 1-р боть, УБ., 2012, 20-21-р тал.

<sup>9</sup>) Hitoshi Kuribayashi, *Word-index to the Secret History of Mongols with Chinese Transcriptions and Glosses*, Sendai. 2009, P176

7. “Монголын нууц товчоо”-ны “馬録”

“Хятад хэлний их толь”-оос үзвэл, хятад хэлний эртний сурвалж бичигт “馬録” (lu) хурдан сайн морийг хэлдэг. Энэ үсэг МНТ-нд нэг удаа тохиолдож байгаа бөгөөд (曲駱兀揚 - kǔlú'út) зайлшгүй дуудлагын хувьд морины утгатай үгс тохирч байгаа тохиолдолд сонгох нь зөв.

8. “Монголын нууц товчоо”-ны “騮”

Хятад хэлний их тольд “騮” (li) бол гүн хар зүсэмтэй морийг хэлдэг. Энэхүү морь хэмээх үгийг галиглсан үсэг “秣騮” МНТ-нд 108 удаа давтагджээ. Морийг тэмдэглэж байгаа үсгийн хувьд сонгон хэрэглэх нь зүйн хэрэг. Гэхдээ МНТ-г галигласан мэргэд “舌” (she) гэсэн тэмдэг тавьж (li)-г (ti)-ээр сэлгэцүүлж унших болгосон байна. Ингэснээр монгол хэлний авиаг зөв ялган уншиж, зөв ойлгох аргыг бидэнд олгосон байна.

9. “Монголын нууц товчоо”-ны “驪”

Хятад хэлний их тольд “驪” (li) бол гүн хар зүсэмтэй морийг хэлдэг. Энэхүү морь хэмээх үгийг галиглсан үсэг “秣驪” МНТ-нд 1 удаа тохиолдож байна. Монголын нууц товчоог хуулан бичиж байсан бичгийн эрдэмтэн гар сэлгэн бичсэн эсвэл алдаж бичсэн байдал харагдаж байна.

10. “Монголын нууц товчоо”-ны “騮”

“騮” (rin) үсэг МНТ-нд “秣騮” (morin) гэсэн үгэнд 11 удаа гарч байна. Хятад хэлний их тольд “騮” (lin) эрслэн, хятадын эртний домогт гардаг арслантай төстэй амьтан, хожим нь сайн морийг ч ингэж нэрлэдэг болжээ. Галиг үсэг оруулах утгын хувиар тохиромжтой боловч (l) ба (r) гийгүүлэгчийг МНТ-г галиглаж байсан бичгийн эрдэмтэд “舌” (she) тэмдгийг жижиг үсгээр өмнө дээд өнцөгт нь бичиж “r” болгон уншихад хүргэсэн байна.

11. “Монголын нууц товчоо”-ны “驢”

“驢” (te) үсэг “驢箠” гэсэн үгэнд 10 удаа давтагджээ. Хятад хэлний их тольд “驢” (tie) хүрэн зүсмийн морийг хэлдэг гэж тэмдэглэжээ. Авианы тохируулга нь (te) болно. Хятад хэлэнд тэмээг (骆驼) “骆驼” гэх буюу “驼” (tuo) гэдэг. “驼” дангаараа тэмээг зааж болдог. Монголчууд тэмээ, морь хоёрыг ялган тэмдэглэдэг бөгөөд нэг төрлөөр үзэхгүй. Хятад улс мал аж ахуй, тэжээлийн төрөл зүйл ховор, голдуу тариалах аж ахуй эрхэлдгээс таван хошуу малыг ялгаж тэмдэглэдэггүй дутмаг тал харагдана. Жишээлбэл: ямааг “山羊” (shanyang), хонийг “绵羊” (mian yang) хэмээн тэмдэглэсэн нь “羊” гэсэн тэмдгийг түлхүүр үсэг болгон хэрэглэн хонь ямааг тэмдэглэжээ. Тэмээг үүнтэй ижил шинжтэй хэмээн үзэж болно. Иймээс уг үсгийг сонгон хэрэглэхэд хүрсэн байна.

12. “Монголын нууц товчоо”-ны “驛”

“Монголын нууц товчоо”-ны “荅驛兒”(dayir) гэх нэг үгэнд хоёр удаа гарч байна. Хятад хэлний их тольд “驛” (yi) өртөө улаа, өртөө залгуулах хэмээн тэмдэглэжээ. Мөн л тэр үед мориор гүйцэтгүүлж байсан учраас тийн морьтой холбоотой үсгээр тольд тэмдэглэн үлдээсэн байдал харагдаж байна.

“Монголын нууц товчоо”-г галиглахад хэрэглэсэн “馬” тэмдэгт 12 үсгийг хүснэгтлэн үзүүлбэл дараах мэт.

№	МНТ-ны хэлбэр	МНТ-ны дуудлага	МНТ дахь давтамж	ХХИТ-ны хэлбэр	ХХИТ-ны дуудлага	ХХИТ-д Үсгийн тайлбар
1	馬	[ma]	399	馬 2030 х	[mä]	Морь, хүлэг, агт, адуу
2	馬弱	[ta]	62	байхгүй		
3	馬騾	[ru]	1	騾 2046 х	[luy]	Луус (морь илжиг хоёрын дундаас гарсан амьтан)
4	馬孛	[bo]	2	孛 2038 х	[by]	Хятадын эртний домогт гардаг нэг төрлийн морь (үхэр сүүлтэй, цагаан биетэй, нэг эвэртэй)
5	馬騾	[ru]	2	байхгүй		
6	馬鼻	[ьн]	1	байхгүй		
7	馬騾	[lu]	1	騾 2041 х	[luy]	Хятадын эртний сурвалжид гардаг хурданы морь
8	馬騾	[ri]	108	騾 2050 х	[ln]	Гүн хар өнгөтэй морь
9	馬騾	[ri]	1	騾 2050 х	[ln]	Гүн хар өнгөтэй морь
10	馬騾	[rin]	11	騾 2048 х	[lnn]	Эрслэн (хятадын эртний домогт гардаг арслантай төстэй амьтан, хожим нь сайн морийг ч ингэж хэлдэг болж)
11	馬騾	[te]	10	騾 2048 х	[tiě]	Хүрэн өнгөтэй морийг хэлдэг
12	驛	[yi]	2	驛 2048 х	[ym]	Өртөө улаа, өртөө залгуулах

Морь гэсэн утгыг илтгэх “馬”-аас бусад олон тэмдэг хятад хэлэнд байсаар атал гагцхүү энэ л үсгийг авч хэрэглэсэн нь бидэнд үгийн утгыг ойлгуулахад тус дөхөм болж байна. Үүнийг морьтой холбоотой үгийн түлхүүр үсэг болгон “Монголын нууц товчоо”-нд авч хэрэглэсэн нь “Монголын нууц товчоо”-г галиглахад хятад бичгийн эрдэмтдээс гадна монгол бичгийн эрдэмтэд ч гол үүрэгтэй ажиллаж байсныг харуулж байна. Энэ мэтчлэн утга зүйн хувьд бичгийн бүтцийг үндэслэн галигласан хятад үсэг олон байна. Энэхүү судалгаанд тулгуурлан МНТ-г галиглахаар зохиож хэрэглэсэн зохиомол үсэг цөөн бус байгааг харуулахыг зорьсон юм.

## НОМ ЗҮЙ

1. 元朝秘史 忙<sup>中</sup>豁<sup>中</sup>倫<sup>中</sup>紐<sup>中</sup>察<sup>中</sup> 脱<sup>中</sup>察<sup>中</sup>安, МНТ-ны арван тавтын бар.
2. Чэнь Юань, “Монголын нууц товчоо” -ны авиа орчуулгад хэрэглэсэн үсгийн шинжлэл. Бээжин 1933 он.
3. Широ Хаттори, 服部四郎 “Монголын нууц товчоо”-н дахь монгол үгийг илтгэсэн хятад үсгийн судлал. Япон 1946 он.
4. Баяр, “Монголын нууц товчоо”, Хөххот 1980 он.
5. Даваа, “Эртний монгол хэл сурах лавлалт”, ӨМСХХХ., 1990 он.
6. Сумьябаатар, “Монголын нууц товчоо” УБ., 1990 он.
7. 李格非, 漢語大字典, 四川辭書出版社, 一九九六年, 成都。
8. Хасбагана, “Дундад зууны монгол хэлний судлал” ӨМСХХХ., 1996 он.
9. Шонхор, “Эртний монгол хэлний судлал”, ӨМСХХХ., 1996 он.
10. “Монгол хятад толь” ӨМСХХХ., Хөххот 1999 он.
11. Ш.Озова, “Монголын нууц товчоо”-ны ертөнц, ӨМАХХ., 1998 он.
12. Шонхор, “Монголын нууц товчоо”-ны сэргээлт, ӨМАХХ., 2002 он.
13. Гарди, “Дундад эртний монгол хэлний судлал” Ляонин үндэстний хэвлэлийн хороо, 2001 он
14. Шонхор, “Монголын нууц товчоо”-ны сийрүүлэлт, ӨМАХХ., 2002 он.
15. Гарди, Дундад эртний монгол хэлний судлалын удиртгал, ӨМАХХ., 2008 он.
16. Hitoshi Kuribayashi, Word-index to the Secret History of Mongols with Chinese Transcriptoins and Glosses, Sendai, 2009.
17. Т.Дашцэдэн, “Монголын нууц товчоо” эх бичгийн латин галиг, УБ., 2009 он.
18. Ш.Чоймаа, “Монголын нууц товчоо” эртний хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, УБ., 2011 он.
19. “Хятад монгол толь” үндэстний хэвлэлийн хороо 2011 он.
20. Б.Сумьябаатар “Монголын нууц товчооны хэлбэр судлал I” УБ., 2012 он

## ABSTRACT

This paper is related to the transcription system of the *Secret History of the Mongols*. In this unique work, there are many ways to transcribe Mongolian words by Chinese characters. For instance, compound ideogram translated as logical aggregates or associative compounds is commonly used. These characters have been interpreted as combining two or more pictographic or ideographic characters to suggest a third meaning.

I aim to consider on a case of Chinese pictogram 馬 (ma) which means horse. The 馬 is used to compose 12 different characters: 馬, 駟, 騾, 馬字, 騾, 馬, 騾, 騾, 騾, 騾, 騾, 騾. The main focus is based on two points: frequency of 12 characters and its explanation. The characters are used 600 times in SHM.

According to the study, one can see that there are many intentionally composed characters in Chinese for transcription of the *Secret History of the Mongols*.